

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 9

1. *Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудал*

4 – 9

---

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 33 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.*

*Томилолттой: Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж;*

*Чөлөөтэй: Б.Бейсен, С.Амарсайхан, П.Батчимэг, С.Ганбаатар, Ж.Золжаргал, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Н.Наранбаатар, Ц.Туваан, Ж.Чинбүрэн;*

*Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг, З.Мэндсайхан.*

***Нэг.Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудлыг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төхөөрөмжөөр санал хураах боломжгүй байгаа тул санал хураалтыг гар өргөж явуулъя гэсэн горимын санал гаргав.

**Б.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Бат-Эрдэнэ:** Агаар, орчны бохирдлын дэд хорооны бүрэлдэхүүнийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Бат-Эрдэнэ:** Хүнс, хөдөө аж ахуйн дэд хорооны бүрэлдэхүүнийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 26 минут үргэлжилж, 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр 10 цаг 59 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Их засаг” танхим  
10 цаг 33 минут

### БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Бат-Эрдэнэ:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгээд өчигдөр манай Пүрэвийн Батчимэг гишүүн Аж үйлдвэрийн гавьяат ажилтан хэмээх өндөр дээд цолоор шагнагдсан явдалд талархал илэрхийлье. Баяр хүргэе.

Ингээд нэг гавьяатаар бүл нэмлээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Наранцэцэгийн Алтаншагай, Очирбатын Амгаланбаатар, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Жигжидийн Батжаргал, Пүрэвийн Батчимэг, Гомбын Ганбаатар, Мөнгөнцогийн Ганхүлэг, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Жаргалсайханы Золжаргал, Цагаанхүүгийн Идэрбат, Мэндбаярын Мандухай, Цагаанхүүгийн Мөнхбат, Тогтмолын Мөнхсайхан, Салдангийн Одонтуяа, Агваанлувсангийн Ундраа гишүүд хүрэлцэн ирснээр ирц 51.7 хувьтай болсон учраас 2025 оны 07 сарын 09-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг Та бүхэндээ албан ёсоор танилцууллаа.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэндээ танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Агаар орчны бохирдлын болон Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудлыг өнөөдөр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороогоор хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай саналтай байвал. Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын Агаар орчны бохирд Бохирдлын дэд хорооны бүрэлдэхүүн болон Хүнс, хөдөө аж ахуйн дэд хорооны бүрэлдэхүүнтэй холбоотойгоор Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Аюушийн Ариунзаяа гишүүнийг үг хэлэхийг хүсэж байна.

**А.Ариунзаяа:** Баярлалаа. Сайн байцгаана уу?

Монгол Улсын Их Хурлын зарим дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хоёр дэд хороо хамаарагдаж байна.

Агаар, орчны бохирдлын болон Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороод.

-Агаар, орчны бохирдлын дэд хороонд 10 хүнтэй.

- 1.Наранцэцэгийн Алтаншагай;
- 2.Бат-Өлзийн Бат-Эрдэнэ;
- 3.Сонгобайн Замира;
- 4.Жаргалсайханы Золжаргал;
- 5.Нанзадын Наранбаатар;
- 6.Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан;
- 7.Жигжидийн Чинбүрэн;
- 8.Салдангийн Одонтуяа;
- 9.Ухнаагийн Отгонбаяр;
- 10.Агваанлуvsангийн Ундраа.

-Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороо 10 хүнтэй.

- 1.Жигжидийн Батжаргал;
- 2.Дамдинсүрэнгийн Жаргалсайхан;
- 3.Цагаанхүүгийн Идэрбат;
- 4.Сүрэнжавын Лүндэг;
- 5.Мэндбаярын Мандухай;
- 6.Загджавын Мэндсайхан;
- 7.Цагаанхүүгийн Мөнхбат;
- 8.Баатаржавын Мөнхсоёл;
- 9.Цэвэгдоржийн Туваан;
- 10.Тогтмолын Мөнхсайхан.

Танилцуулж дууслаа.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Хоёр дэд хорооны асуудал учраас эхлээд Агаар, орчны бохирдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

---

**П.Батчимэг:** Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд харьяалагдах хоёр дэд хороонд гишүүдээсээ Байнгын хорооны гишүүдээсээ санал авсан юм болов уу. Би бол яг биечлэн сонсоогүй. Тэгээд одоо л сонсож байна.

Тэгэхээр мэдээлэл бас хомс явсан юм шиг байна. Мэдээллээс хоцорсон ч байж магадгүй. Зүгээр гишүүнийхээ хувьд санал хэлэхэд одоо манай бүлгээс бол энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд яг харьяа юу? Гишүүний хувьд бол ажиллана.

Тэгээд нэг дэд хороонд нь орох саналтай л байна. Чухам одоо энд саналаа өгч болдог юм болов уу? Эсвэл би бүлгийн даргатай бүлэг дээрээ саналаа оруулах юм уу?

**Б.Бат-Эрдэнэ:** П.Батчимэг гишүүн өөрийнх нь санал байгаа юу танд? Хүнс, хөдөө аж ахуйн. Тийм. Бас ажлын хэсэг энэ тэрд ороод ажиллаад явдаг л даа. Шинэ хоршоо энэ тэр дээр одоо ингээд л бас ажлын хэсэг явж л байгаа.

А.Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

**А.Ариунзаяа:** Асуултад хариулъя. Бүлгийн удирдлагуудтай зөвшилцсөн.

Ер нь Байнгын хороодын тоо 32-оос илүүгүй байна. Нэг Байнгын хороо хоёрын нэгээс илүүгүй байна гэдгээрээ явж байгаа.

Тэгээд тухайн улс төрийн намуудын хувь, Улсын Их Хуралд эзэлж байгаа суудлын хувь, хэмжээтэй нийцэх байдлаар дахиад дэд хороод нь хуваарилагдаж байгаа. Тийм ээ. Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороон дээр 10 хүн байна.

Тэгэхээр Пүрэвийн Батчимэг гишүүн өөрийн саналаараа Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороонд бас нэмэгдэх саналыг гаргаж болно. Харахад улс төрийн намуудын суудлын хувь, хэмжээ зөрөхөөргүй байгаа учраас Пүрэвийн Батчимэг гишүүний саналыг хүлээн авч Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороонд хамааруулж болж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороон дээр Агаар, орчны бохирдлын дэд хороон дээр сая өөр санал байхгүй гэж ойлгосон.

**Б.Бат-Эрдэнэ:** Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороон дээр Т.Мөнхсайхан гишүүн.

---

Т.Мөнхсайхан гишүүний микрофоныг өгье.

**Т.Мөнхсайхан:** Санал өгөх гэж байгаа юм биш үү?

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Ойлголоо. Тэр нэрсийг нь өгөх үү? Агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хороо, Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороон дээр санал авч дууслаа. /алх цохив/

Хүнс, хөдөө аж ахуйд санал байгаа юу? Сая би асуулт байна уу гэсэн. Хүнс, хөдөө аж ахуй дээр санал байна уу гээд Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороон дээр санал.

М.Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** Мэдээлэл авчихлаа. Тийм. Боллоо. Баярлалаа.

**Б.Бат-Эрдэнэ:** Ойлголоо. Баярлалаа.

Ингээд Агаар, орчны бохирдлын дэд хорооны бүрэлдэхүүний асуудалд бүрэлдэхүүний тухай асуудалтай холбоотой үг хэлэх гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Тэгэхээр одоо санал хураалт явуулна.

Агаар, орчны бохирдлын дэд хорооны бүрэлдэхүүнийг батлахтай холбоотой санал хураалтыг явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдэхийг хүсэж байна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Г.Ганбаатар гишүүн, Д.Жаргалсайхан гишүүн байхгүй байна. Тийм ээ. Хүлээж байя. Н.Алтаншагай гишүүн ирцэд орсон байна даа. Н.Алтаншагай гишүүн.

Төхөөрөмж нь гацчихаад байгаа.

Протокол үйлдэх юм. Та бас энэ дээрээ. Би бас утсан дээр бичиж байгаа юм чинь. Би ярьж байгаа зүйлүүдийг өнөөдрийн хуралдааны протоколд цаасан суурь дээр нь тусгаарай.

Манайхан анхаараарай.

---



Жигжидийн Батжаргал гишүүний гаргасан саналын дагуу техникийн алдаа гарсан учраас аудио протоколыг гар утсанд ахлах зөвлөх бичээд, ажлын албаныхан бичгээр үйлдээд ингээд илээр гар өргөх байдлаар санал хураалтыг явуулъя гэдэг.

Эхлээд горимын санал гаргая. Горимын саналыг дэмжих гишүүд нь гараа өргөнө үү. /алх цохив/

1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10 гишүүн.

15 гишүүнээс 10 гишүүн хуралдаанд оролцож байна. Дэмжлээ.

Нийт гишүүдийн олонхоор дэмжсэн учраас илээр санал хураалт явуулъя.

Санал хураалтаа явуулъя.

Монгол Улсын Их Хурлын Агаар, орчны бохирдлын дэд хороог Монгол Улсын Их Хурлын гишүүн

Наранцэцэгийн Алтаншагай,  
Бат-Өлзийн Бат-Эрдэнэ,  
Жигжидийн Чинбүрэн,  
Ухнаагийн Отгонбаяр,  
Нанзадын Наранбаатар,  
Сонгобайн Замира,  
Агваанлуvsангийн Ундраа,  
Жаргалсайханы Золжаргал,  
Салдангийн Одонтуяа,  
Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан нарын бүрэлдэхүүнтэйгээр  
байгуулахыг дэмжъя саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцогч 15-аас 10 гишүүн буюу олонхын саналаар дэмжлээ.

Хоёр дахь санал байна. Дараагийн санал руугаа оръё.

Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороог Монгол Улсын Их Хурлын гишүүн

Мэндбаярын Мандхай,  
Жигжидийн Батжаргал,  
Цагаанхүүгийн Идэрбат,  
Загджавын Мэндсайхан,  
Сүрэнжавын Лүндэг,

---

Баатаржавын Мөнхсоёл,  
Цэвэгдоржийн Туваан,  
Дамдинсүрэнгийн Жаргалсайхан,  
Цагаанхүүгийн Мөнхбат,  
Тогтмолын Мөнхсайхан,  
Пүрэвийн Батчимэг гэсэн гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг  
дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

15-аас 10. Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх буюу 10 гишүүн  
дэмжсэн учраас санал хураалтыг дэмжсэнд тооцлоо.

Санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын Агаар, орчны бохирдлын  
болон Хүнс, хөдөө аж ахуйн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг  
хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн  
Мөнгөнцогийн Ганхүлэг танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул  
өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 10 цаг 59 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**